

## 09. Ээлжит хичээлийн хуваарийн өөрчлөлт бүртгэх

Ээлжит хичээлийн хуваарь солих

Хичээлийн хуваарь засварлахад дараах өөрчлөлт орсон

1. Улирал тус бүрт Хонх дуугарах хуваарийг /ХДХ/ тохируулах боломжтой болсон
2. Улирлын дундуур хичээлийн хуваарь өөрчлөгдсөн бол огноог сонгож хуваарь өөрчлөх боломжтой болсон.

**Анхаарах нь:**

- Тухайн хичээлийн багш солигдсон бол сургалтын менежерийн эрхээс Ээлжит хичээлийн үйлдэл цэснээс багш солих үйлдлээр солих боломжтой.

Жич: Ээлжит хичээлийг цуцлах шаардлагагүй

- Тухайн хичээл орох улирлын сонголтыг мөн сургалтын менежерийн эрхээс тохируулна.
- Улирлын дунд хичээлийн хуваарийн өөрчлөлийг огноогоор бүртгэж оруулахад өмнө бүртгэсэн ирц харагдахгүй болох тул ирцийн бүртгэлийн хяналт хийж улирлын дунд хуваарийн өөрчлөлтийг бүртгэнэ үү.

### **1. Хэрвээ Батлагдсан ээлжит хичээлийн хуваарийг АУБ-ийн эрхээр бүртгэх**

Анги удирдсан багшийн эрхийн ээлжит хичээлийн жагсаалтаас Хуваарь засварлах үйлдлээр ээлжит хичээлийн улирал тус бүрийн хуваарийн өөрчлөлтийг бүртгэх боломжтой.

## Зураг1: Багшийн эрхээр хуваарь солих

## Зураг2: Хуваарь солих үйлдэл

1. Хичээлийн хуваарь солих улирлыг сонгох
2. Улирал тус бүрийн Хонх дуугарах хуваарь /ХДХ/-г солих боломжтой
3. Зөвхөн Улирлын дунд хичээлийн хуваарийг өөрчлөгдсөн тохиолдолд огноог ашиглаж хуваарийн өөрчлөлтийг хадгалана. Хэрвээ тухайн улиралд нэг хичээлийн хуваариар хичээл явагдсан бол огноог өөрчлөлтгүйгээр хадгална уу.
4. Хичээлийн хуваарь өөрчлөх бүртгэл
5. Хуваарь хадгалах товчийг дарснаар хичээлийн хуваарийн өөрчлөлт хадгалагдаж багш цахим журнал хөтлөх боломжтой болно.

## **2. Сургалтын менежерийн эрхээс хичээлийн хуваарь бүртгэх**

Сургалтын менежерийн эрхээс хичээлийн хуваарийн өөрчлөлтийг бүртгэхийн тулд Ээлжит хичээл дотор батлагдсан ээлжит хичээлийн жагсаалтаас

тэмдэгтийг дарж Хуваарь солих товчийг дарж бүртгэл хийнэ.

### Зураг3: Сургалтын менежерийн эрхээс ээлжит хичээлийн хуваарь бүртгэх

### Зураг 4: Хичээлийн хуваарийн бүртгэл

1. Хичээлийн хуваарь бүртгэх улирал сонгох
2. Тухайн улирлын хичээлийн хуваарь улирлын дунд өөрчлөгдсөн бол Хонх дуугарах хуваарь /ХДХ/ болон өөрчлөлт бүртгэх огноог бүртгэнэ.
3. Хичээлийн хуваарь өөрчлөгдсөн түүхийг харах боломжтой. Уг түүх устгах боломжгүй тул хичээлийн хуваарийг өөрчлөлтүүдийг бүртгэх шаардлагагүйгээр бүртгэнэ үү
4. Хичээлийн хуваарийн өөрчлөлтийг бүртгэж хадгалах товч дарснаар багш цахим журнал хөтлөх боломжтой болно.